

## Хүний хөгжлийн санхүүжилт (цуврал 2)

*МУИС-ийн ЭЗДС-ийн багш,  
доктор, профессор Д. Цэрэнпил*

### 2. Мөнгө, санхүү, төсөв

Хүний хөгжлийн санхүүжилтийн материаллаг үндэс нь тус улсын дотоодын нийт бүтээгдэхүүн юм. Энэ мөнгөн гүйлгээ, төсөв санхүүгийн бусад механизмаар дамжин хэрэгждэг.


*Мөнгө, зээл :* Мөнгө зээлийн үйл ажиллагааг бэхжүүлэх нь улсын санхүүг эрүүлжүүлэх, хүний хөгжлийн санхүүгийн хангамжинд хамгийн хүчтэй нөлөө үзүүлнэ. Инфляцийн өсөлтийг бууруулах, төгрөгийн худалдан авах чадварыг тогтвортой байлгах, төлбөрийн тэнцлийг сайжруулах, үйлдвэрлэл үйлчилгээг нэмэгдүүлэхэд мөнгөний бодлогыг чиглүүлж, зээлийн хүүг инфляцийн түвшинтэй харьцуулахад эерэг түвшинтэй байлгах нөөцийн шаардлагыг хангуулах, иргэдийн богино хугацаатай хадгаламжинд төлөх хүүгийн доод хэмжээг тогтоож мөрдүүлэх, арилжааны банкуудаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгох зээлийн үлдэгдэл хязгаар тогтоох зэргээр мөнгөний удирдлагын шууд ба шууд бус хэрэгслүүдийг хослуулан ашиглаж байна. Гүйлгээний хүрээнд төгрөгийн зохиомол хомсдол арилж, мөнгөний байршилтад болон эргэлтийг түргэтгэхэд ахиц гарлаа. 1995 оны гүйцэтгэлээр нийт мөнгө 102.0 тэрбум төгрөгт хүрч, оны эхнээс 32.8 хувь төгрөгөөр өсчээ. Нийт мөнгөний бүтцэд төгрөгийн хадгаламж 37.7 хувь, банкнаас гадуурхи бэлэн мөнгө 25.0 хувь, гадаад валютын хадгаламж 20.5 хувь, банкин дахь аж ахуйн нэгж, байгууллагын харилцааны харилцах дансны үлдэгдэл 16.8 хувийг тус тус эзэлж байна. Хүн амын хадгаламж 1995 оныхоос 4.6 дахин нэмэгдэв.

Арилжааны банкууд төрөөс явуулж байгаа мөнгөний бодлогын хүрээнд үйлдвэрлэлийг дэмжих, хувийн хэвшлийг хөгжүүлэх, хүн амын өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэл, хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, ажлын нэмэгдэл байр бий болгоход чиглэсэн үр ашигтай төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд анхаарч, үүнд зээл хүүгийнхээ бодлогыг чиглүүлж байна.

*Төсөв, санхүү:* Засгийн газрын гарааны нөхцөл тун хүнд байсан. Улсын төсвийн нийт алдагдал 1991 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 15.1 хувьтай тэнцэж байна. Зах зээлд шилжиж буй нөхцлийг харгалзан санхүү, төсвийн цэгцтэй бодлого боловсруулж хэрэгжүүлснээр улсын төсвийн орлого, зарлагын бүтэц, татварын тогтолцоонд өөрчлөлт гарч, улс орны санхүүгийн систем эрүүлжих эхлэл тавигдлаа. Төсөв санхүүгийн бодлогыг эдийн засгийг тогтворжуулах, цаашид эдийн засгийг сэргээх, хүний хөгжлийн нөхцөл бүрдүүлэхийн тулд төсвийн орлогын баазыг өргөтгөх, татварын хэмжээг нийгмийн хэрэгцээ болон эдийн засгаа сэргээн идэвхжүүлэх шаардлагад нийцүүлэн тогтоох арга хэмжээг авч байна. Төсвийн орлого, зарлага өсөхийн

зэрэгцээ бүтэц бүрэлдэхүүн нь өөрчлөгдлөө. Төсвийн орлогын динамик болон бүтцийг Зураг1, хүснэгт 1-ээс үзнэ үү.

Зураг-1



Манай улс ДНБ-д албан татварын орлого 28.1 хувь болоод байгаа бөгөөд төсвийн нөөцийн 80 хувийг бүрдүүлж байна.

Улсын төсвийн зарлагын бүтцийг боловсронгуй болгох зорилгоор нийгэм хангамж, эрүүл мэндийн үйл ажиллагааг даатгалын тогтолцоонд шилжүүлж, удирдлагын зардлын бүтцийг боловсронгуй болгон өөрчлөх, мэргэжлийн сургалтыг төлбөртэй болгох зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, улсын төсвийн орлого, зарлагад тавих хяналтыг чангатгах, төсвийн зарлагыг зохистой хэмжээнд хязгаарлах бодлогыг явуулж байна. Төсвийн зарлагын бүтцийг эдийн засгийн үйл ажиллагааны ангилалаар хүснэгт 2-т харуулав.

Монгол улсын төсвийн орлого 1991-1995 оноор  
(оны үнээр, сая, төгрөг)

Хүснэгт-1

	1992		1993		1994		1995	
	Дүн	Хувийн жин %	Дүн	Хувийн жин %	Дүн	Хувийн жин %	Дүн	Хувийн жин %
1. Нийт орлого ба тусламж	11301.2	100	54843.3	100	86131.4	100	144622.9	100
2. Нийт орлогын дүн	11301.2	100	51816.4	94.5	82866.0	96.2	139538.1	96.5
3. Урсгал орлого	11289.6	99.9	51816.4	94.5	82194.0	99.2	135683.6	97.4
3.1. Татварын орлого	10231.0	90.5	49810.1	96.1	67596.4	81.5	105509.7	75.6
3.1.1 Орлогын албан татвар	5475.1	48.4	28439.7	54.9	32040.6	38.7	48527.3	34.8
- Хүн амын орлогын татвар	239.8	2.1	1272.6	2.5	2165.7	2.6	5103.0	3.8
- Аж ахуйн нэгжийн татвар	5235.3	46.3	17167.1	52.4	29874.9	36.1	43236.3	31.0
3.1.2 Нийгмийн даатгалын шимтгэл	-	-	-	-	6418.8	7.7	15764.6	11.3
3.1.3 Худалдааны татвар	93.1	0.8	7139.9	13.8	11343.2	13.7	16254.2	11.6
3.1.4 Онцгой албан татвар	3019.2	26.7	6586.7	12.7	5329.1	6.4	8579.7	6.1
3.1.5 Тусгай үйлчилгээний татвар	8.2	0.1	413.6	0.8	2856.5	3.4	3273.2	2.3
3.1.6 Гаалийн татвар	1449.1	12.8	6578.8	12.7	7541.1	9.1	9571.5	6.9
3.1.7 Бусад татвар, хураамж	186.3	1.6	651.4	1.2	2067.1	2.5	3529.2	2.5
3.2 Татварын бус орлого	1058.6	9.4	2006.3	3.9	14597.6	17.6	30173.9	21.6
3.3 Хөрөнгийн орлого	11.6	0.1	-	-	672.1	0.9	3854.5	2.8
3.4 Гадаад тусламжийн орлого	-	-	3026.9	5.5	3265.3	3.8	5084.8	3.5

1995 оны урьдчилсан гүйцэтгэлээр улсын орлого 136.3 тэрбум төгрөг, зарлага санхүүжилт 147.7 тэрбум төгрөг болж орлогоос давсан зарлага 11.4 тэрбум төгрөг боллоо. 1994 онд улсын төсвийн зарлагын 73.7 хувийг урсгал зардал эзэлж байсан бол 1995 онд 86.8 хувийг эзэлж 4.9 пунктээр буурсан төсвийн зарлагад хөрөнгийн зардал болон гадаад зээл, өрийн төлбөрийг барагдуулах зардлын эзлэх хувь хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой байна.

Улсын төсвийн зарлагын 17.3 хувийг цалин хөлс, 11,2 хувийг аймаг, нийслэлийн төсөвт өгөх татаас, 28,7 хувийг төрийн байгууллагын болон нийгмийн ерөнхий үйлчилгээний зардал зэрэг урсгал зардлыг санхүүжүүлэхэд зарцуулсан байна. Төсвийн зарлагыг эдийн засгийн бүтцээр нь үзвэл 15.8 хувийг боловсролын үйл ажиллагаа, 12.0 хувийг эрүүл мэндийн үйл ажиллагаа, 14.8 хувийг нийгмийн тэтгэвэр, халамж, 3.1 хувийг соёл, урлаг, спортын үйл ажиллагаа, 7.2 хувийг эрчим хүч, дулаан хангамжийн үйл ажиллагааны санхүүжилтэд зориулсан байна. Монгол улсын төсвийн орлого, зарлага өсөн нэмэгдэж, бүтцийн хувьд өөрчлөгдөж байгаа боловч алдагдалтай хэвээр байгаа.

### Монгол улсын төсвийн алдагдал (сая төгрөг)

Хүснэгт 3

	1991	1992	1993	1994	1995
Алдагдлын дүн	2432.1	1059.6	6818.6	15194.7	11456.2
ДНБ-д эзлэх хувь	12.9	2.2	4.1	5.4	2.9
Төсвийн зарлагад эзлэх хувь	27.2	8.6	11.1	15.0	7.8

1995 онд улсын төсвийн нийт алдагдал 11.4 тэрбум төгрөг болсон нь 1994 оныхоос 24.6 хувиар буюу 3.7 тэрбум төгрөгөөр буурч, улсын төсвийн урсгал дансны ашиг 1994 оныхоос 2.9 дахин буюу 14.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвийн байдалд зохих ахиц гарч байгааг харуулж байна. Төсвийн алдагдал туйлын хэмжээгээр нэмэгдэх төлөвтэй байгаа нь хүний чадавхийг хөгжүүлэх санхүүжилтэнд сөрөг нөлөөтэй байх болно. Өнгөрсөн хугацаанд орон нутгийн төсвийн орлого, зарлага ерөнхий дүнгээрээ нэмэгдсэн. Энэ нь боловсрол, эрүүл мэнд нийгэм соёлын арга хэмжээ, хүн амын аж амьдралын түвшинг дээшлүүлэх санхүүжилтэд сайн нөлөө үзүүлнэ. Гэхдээ орон нутгийн төсөв нь улсын байнгын татаастай байлаа.

Төрөл	1991	1992	1993	1994	1995
Дүн	142200	152408	218823	22013	20823
Хувийн	100	82	148	18	18.4
Урьдчилсан	100	100	150	15	21
Хувийн	100	100	150	15	21

Монгол улсын төсвийн зардалта  
(Эдийн засгийн үйл ажиллагааны чиглэлээр, сая төгрөг)

Хүснэгт 2

	1991		1992		1993		1994		1995	
	Дүн	Хувийн жин %	Дүн	Хувийн жин %	Дүн	Хувийн жин %	Дүн	Хувийн жин %	Дүн	Хувийн жин %
Нийт зардалта	8929.3	100	12360.9	100	61661.9	100	101326.1	100	147730.6	100
Нийгмийн ерөнхий үйл ажиллагаа	910.1	10.2	888.3	7.1	3615.1	5.9	8392.5	8.3	12540.8	8.5
Батлан хамгаалах	738.0	8.3	945.4	7.6	4238.5	6.9	7016.6	6.9	10781.7	7.3
Нийгмийн хэв журам, аюулгүй байдлын үйл ажиллагаа	253.0	2.8	849.4	6.9	2186.4	3.5	4233.3	4.2	6292.2	4.3
Боловсрол	2049.0	22.9	3273.2	26.5	9595.6	15.6	16439.0	16.2	23415.3	15.8
Эрүүл мэнд	1109.7	12.4	1944.4	15.7	6329.7	10.3	11609.9	11.5	17754.4	12.0
Нийгмийн тодорхой хэсэгт зориулсан (тэтгэж, тэтгэвэр, халамж)	1050.2	11.8	1577.5	12.8	5717.8	9.3	13459.2	13.3	21887.3	14.8
Орон сууцн нийтийн аж ахуйн үйл ажиллагаа	238.3	2.7	199.5	1.6	1023.2	1.5	1493.2	1.5	1831.6	1.2
Соёл,спорт, телевиз мэдээлэл	393.0	4.4	698.8	5.7	2347.6	3.8	3844.0	3.8	4526.5	3.1
Эрчим хүч, дулаан хангамж	422.3	4.7	131.3	1.1	3348.0	5.4	7522.2	7.3	10597.0	7.2
Хөдөө аж ахуй, ойн аж ахуйн үйл ажиллагаа	282.0	3.2	639.2	5.2	1539.3	2.5	2182.7	2.2	2791.3	1.9
Аж үйлдвэр, барилга, эрдэс баялаг	544.2	6.1	389.1	3.1	1139.1	1.8	9829.1	9.7		
Тээвэр холбоо	414.6	4.6	324.3	2.6	1276.3	2.1	4576.2	4.5	3593.4	2.4
Эдийн засгийн бусад үйл ажиллагаа	197.0	2.2	208.3	1.7	5029.3	8.2	2666.6	2.6	3082.7	2.1
Ангилалдаагүй бусад зардал	327.9	3.7	293.2	2.4	14276.0	23.2	8061.6	8.0	28636.4	19.4

## Орон нутгийн төсвийн орлого, зарлага (оны үнээр, сая төгрөг)

### Хүснэгт 4

	1991	1992	1993	1994	1995
Орлого	2713.8	4859.1	12297.1	20674.8	30888.9
Зарлага	3870.9	6177.0	23233.4	33577.5	49081.8
Улсын төсвөөс олгосон татаас	1731.1	2175.6	11576.6	10844.2	16568.8
Зарлагын дүнд татаасын эзлэх хувь	44.7	35.2	49.8	32.3	33.8

1995 онд аймгуудад төвлөрсөн төсвөөс 16.6 тэрбум төгрөгийн татаас өгсөн нь тэдгээрийн нийт зарлагын 33.8 хувьтай тэнцэж байна. Цаашид аймаг орон нутгийн бие даасан хөгжлийг хангах, орлогоороо зарлагаа нөхдөг болгох нь төр засгийн том зорилтын нэг юм. Төсвийн алдагдалтай орон нутгийн санхүүжилтийг хомстолд оруулж, ялангуяа боловсрол, эрүүл мэндийг хамгаалах, нийгэм хангамж, тэтгэвэр, цалингийн зориулалттай зарлагад хязгаарлагдмал хүрэлцээгүй байдлыг бодитой нөхцөлдүүлж байна. Төсвийн алдагдал цаашид үргэлжлэн байх, ихсэх төлөвтэй байгаа нь:

- материаллаг гол салбарын аж ахуйнууд үйлдвэрлэлийн уналтаа зогсоож, сэргээж чадахгүй, санхүүгийн чадвар сул байгаа нь татварын орлогын үндсэн суурь бааз болох ашгийн хомстол бий болгосон

- үнэ болон инфляцийн өсөлтийг зогсоож найдвартай сайжруулж чадахгүй

- зах зээлийн хувиарлалтын нөхцөлд эдийн засаг, нийгмийн зайлшгүй шаардлагатай зардал өсөн нэмэгдэж байгаа

- төсвийн зарлагыг зохисжуулах төлөвтэй, бууруулахгүй байгаа

- мөнгө зээлийн үйл ажиллагаа зах зээлийн жам зүйгээр боловсронгуй болж чадаагүй, ялангуяа үйлдвэрлэлийн тогтворжилт, эдийн засгийн өсөлтөд мэдэгдэхгүй, нөлөөлөхгүй байгаа

- Монгол улс дэлхийн зах зээл, олон улсын хөдөлмөрийн хуваарт өөрийн байраа олж чадаагүй, гадаад өр зээл ихтэй байдал зэрэг хүчин зүйлээс болж байна.

Төлбөрийн баланс : Эдийн засгийн цаашдын өсөлтийг хангах, санхүү мөнгөн гүйлгээний бодлогын үр дүнтэй болгоход гадаад худалдааг идэвхжүүлэх, төлбөрийн балансан тэнцлийг сайжруулах, түүний ханшийг тогтвортой байлгах нэг чухал зүйл болж өгнө. Үүний тулд гадаад худалдааг эрх тэгш, харилцан ашигтай байх зарчмыг үндэслэн чөлөөтэй, нээлттэй хөгжүүлэх бодлогыг явуулж, төлбөрийн балансыг тогтворжуулах нь нэн шаардлагатай бөгөөд үүнийг их анхаарч байна.

**Монголд гадаад худалдаа**  
(оны үнээр, сая ам. доллар)

**Хүснэгт 5**

	1991	1992	1993	1994	1995
Гадаад худалдааны нийт эргэлт	708.9	806.7	761.6	625.6	900.3
Үүнээс: – экспорт	348.0	388.4	382.6	367.5	511.6
– импорт	360.9	418.3	379.0	258.4	388.7
Тэнцэл	-12.9	-29.9	3.6	109.1	122.9

Гадаад нийт эргэлт 1995 онд 900 сая ам. долларт хүрч, урьд онохоос 43.8 хувь, үүний дотор экспорт 39.2 хувь, импорт 1.5 дахин нэмэгдэв. Худалдааны төлбөрийн тэнцэл сүүлийн гурван жил (1992–1995 онд) дараалан ашигтай болж байна. 1995 онд экспорт нь импортоосоо 122.9 сая ам. доллар илүү байв. Монголын аж ахуйн бүх салбар ялангуяа хөдөө аж ахуй, аж үйлдвэр, нийгмийн үйлчилгээний хөгжил, хүн амын хүнс тэжээл, өргөн хэрэглээний барааны хангамж нь импортын барааны нийлүүлэлтэй ихээхэн холбоотой. Эдийн засгийн бүтцийг өөрчлөх, үйлдвэрлэлийн техник технологийг шинчлэх шаардлага хурцаар тавигдаж байна. Гагцхүү энд манай экспорт, валютын нөөц хязгаарлагдмал байдаг. Сүүлийн жилд импортолсон барааны 80 хувь нь үйлдвэрлэл техникийн, 20 хувь нь өргөн хэрэглээний зориулалттай байв. Шилжилтийн нөхцөлд экспорт импортыг зохистой хослуулахдаа, экспортод илүү баримжаалсан үйлдвэрлэл, худалдааг хөгжүүлснээр Монгол орон дэлхийн олон улсын хөдөлмөрийн хуваарт зохих байр суурь эзлэх болно.

**Дүгнэлт:** Шилжилтийн эхний жилүүдэд Монголын эдийн засаг, нийгмийн байдалд зарим нэг ахиц гарсан боловч нэн төвөгтэй, ялангуяа санхүү, мөнгө-зээлийн тогтолцоонд хүнд ээдрээтэй хэвээр байна.

- Үүний гол шалтгаан нь:
- Үнийн өсөлт зогсоогүй, инфляци олигтой буураагүй
  - Эдийн засаг, санхүү, мөнгөн гүйлгээний байдлыг салбар бүрт нь цогцолбороор нь зоригтой өөрчилж, бүрэн тогтворжуулж чадаагүй хэвээр
  - Дотоод бүтэцдээ үйлдвэрлэлийн уналт үргэлжилж, үйлдвэрлэл, хангамж, борлуулалтын зохион байгуулалт, менежмент, маркетингийн болон техник технологийн хоцрогдол, эмх замбараагүй байдал
  - Хөрөнгө, мөнгөний нөөц боломж хомсдож, өр төлбөрийн гэнжин холбоо үүсч, эргэлт нь удааширсан
  - Ажилгүйдэл, ядуурал ихсэж, хүний хөгжил, амьдралын түвшин буурах хандлага байгаа
  - Экспортоо нэмэгдүүлэх, нээлттэй эдийн засгийн бодлого явуулах замаар дэлхийн зах зээл дээр шийдвэртэй алхам хийхгүй, импорт хязгаарлагдмал олон улсын хөдөлмөрийн хуваарьт идэвхтэй оролцож чадахгүй байгаа
  - Дэмжигч ба хандивлагч орон, олон улсын валютын сан, банкны тусламж, зээлийг туйлийн идэвхгүй ашиглаж байгаа зэрэг болно.

Эдийн засгийн ийм байдал нь эргээд хүний хөгжил, түүнийг санжүүлэх боломжинд сөрөг үзүүлж байна.

Монголын эдийн засаг, хүний хөгжил түүний чадавхыг бүрдүүлэхэд ашиглуулах давуу тал, анхаарах сул тал ч байна.

Нөлөөлөл бүхий давуу тал нь:

- Онгон төрхөөрөө хадгалагдаж үлдсэн өргөн уудам нутаг дэвсгэр, байгаль орчин, эдэлбэр газрын ихээхэн нөөц
- Эрдсийн түүхий эдийн олон төрлийн арвин нөөц баялаг
- Уламжлалт мал аж ахуй, түүндээ зохицсон нүүдлийн амьдралын өвөрмөц хэв, маяг, соёл иргэншил
- Хүн ам, хөдөлмөрийн нөөц залуужиж буй бүтэц, тэдний боловсролын харьцангуй өндөр түвшин, бий болсон оюуны чадавхи
- Хил залгаа хоёр том гүрний зах зээлийг ашиглах боломж, олон улсын хөдөлмөрийн хуваарьт оролцох нөхцөл, гадаад орчин.

Тодорхой нөхцөл боломж, өвөрмөц шийдвэрийг шаардах сул тал нь:

- Хүн амын тоо цөөн, хөдөлмөрийн нөөц хязгаарлагдмал боловч ашиглалт муутай, одоо байнгын ажилгүйдэл болсон
- Эдийн засгийн бүх салбарт техник, технологийн түвшин доогуур
- Эдийн засгийн өөрийгөө дотроосоо нөхөн тэтгэх зохистой бүтцийг бүрдүүлээгүй, дэд бүтцийн хөгжил сул
- Далайд гарцгүй, мэдээлэл холбоо харилцааны бэрхшээлтэй
- Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл нь байгалиас ихээхэн хамааралтай
- Экологийн эмзэг орчин, байгалийн нөхөн сэргээгдэх чадвар сул
- Дотоод хуримтлал, хөрөнгө, оруулалт, валютын нөөц ихээхэн хомс, хязгаарлагдмал
- Бүтцээсээ шалтгаалан эдийн засгийн дотоод эрэлт удаантай

Дээр дурьдсан байдал нь Монголд эдийн засгийн өсөлт, хүний чадавхийн, хөгжлийн асуудлын уялдаа харилцан нөлөөллийг улам хүчтэй болгож, шинээр цогцолбор шийдвэрлэхийг шаардаж байгаа нь цаашдаа санхүү, төсвийн бодлогод зайлшгүй тусгагдах ёстой.

Үндэслэл	Хүн ам	Хүн амын өсөлт	Хүн амын өсөлт
1989-1990 онд хүртэл (нийт 35 жилийн турх) төсөл байдлын үндэртэй байсан бөгөөд 20-аад жилд 2.7 дахин өсөж байсан байна. 2019-2020 онд Монгол улсад хүн ам 4.1-4.3 сая болох юм. Хүн амын тооны өсөлт ирэх зууны эхэн үеэр мөн л ургажалттай өсөх хандлагатай байна. Монголын хүн ам 1918 онд 600.5 мян. байсан бол 1989 оны төлөгсөөр 2044.0 мянд хүрч 1918 оныг харьцангуй 3.2 дахин, 1960 оныхоос 2.2 дахин өсч, 1996 оны төлөгсөөр 2312.0 хүрч байгаа ба энэ зууны эцэст буюу 2020 онд 2666.5 мянд хүрнэ. 2019 он гэхэд 400.0 мянд хүрч 1996 оныхоос 1750.0 мянд орчим хүчээр нэмэгдэж төлөгсөж байна. Хүн амын тоо 1918 оныхоос өөрчлөгдөж, ихэвчлэн өсөж байгаа нь 1.7 дахин өсөх хандлагатай байгаа юм. Хүснэгт 2-а хүн амын ихэвчлэн төсөл байдлын өсөлт	1918 онд 600.5 мян.	1989 онд 2044.0 мян.	1996 онд 2312.0 мян.